

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ТҮҮХ

Ж.Баттогтох¹

Эрт дээр үеэс хүмүүс овог аймаг болон өөр хоорондоо харилцан оршин тогтнож байсан. Төр улс үүсэж бий болсноор овог аймгийн харилцаа нь олон улсын харилцаагаар солигджээ. Улс орны дотоод харилцаа болон овог аймгийн, хожим нь улс хоорондын харилцаа нь тодорхой зан үйлийн хэм хэмжээгээр журамлагдаж байв. Анхандаа бичигдээгүй “хууль” (олон улсын заншил) болон үүсэж, дараа нь овог аймгийн түвшинд бичигдмэл хуультай болсон ч орчин үеийн олон улсын эрх зүйн хэв төрхөд хараахан ороогүй байсан.

Ромын хууль зүйн системд харъяат, харъяат бус хүмүүсийн хоорондын харилцааг тодорхойлох эрх зүйн хэм хэмжээг “jus gentium” буюу ард түмний эрх гэж нэрлэж байсан. Эл ойлголтыг Дундад зууны үед олон улсын харилцааны зохицуулах хуулийн хэм хэмжээ гэж ойлгох болжээ.

Эртний Хятад, Энэтхэг, Грек, Ром нь эртний дорно дахины соёлын гол төв байв. Нийгмийн хөгжлийн явцад Ази, Африкт ч ийм төвүүд бүрэлдэн үүссэн. Эдгээр төвүүдэд байршсан улс орны хооронд төрөл бүрийн харилцаа үүсч, улмаар түүнийг зохицуулах зорилго бүхий олон улсын эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэн бий болсон түүхтэй. Бүс нутгийн төвүүдийг төлөөлж байсан улс орны хооронд ихэвчлэн хоёр талын шинжтэй харилцаа давамгайлж байсны зэрэгцээ, тухайн орон нутгийн хүрээнд үйлчлэх хууль дүрэмтэй байв.

Эрт үед бүтээгдсэн олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь өөрчлөгдөн засагдаж, орчин үеийн улс гүрний харилцааг зохицуулах дүрэм журамд шингэн орсон байдаг. Тухайлбал, дипломат эрх, олон улсын гэрээ хэлэлцээрийн өнөөгийн байдалд тусгалаа олсон юм.

Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур байдаггүй тул олон улсын эрх зүйн түүхийг үечлэх асуудал нь нарийн төвөгтөйд тооцогддог.

Олон улсын эрх зүйн түүхийн үечлэл

Олон улсын эрх зүйн түүхийн үечлэл олон улсын харилцааны үечлэлтэй салшгүй холбоотой ба олон улсын харилцааг зохицуулах хэм хэмжээний үүсэл, хөгжил, төлөвшилтийн үйл явц нь түүхэнд тохиолдсон эргэлтийн үетэй шууд холбоотой байдаг онцлогтой. Үүнтэй уялдан олон улсын эрх зүйн түүхийг дараах маягаар үечилж болно:

1. Эртний үеийн олон улсын эрх зүй;
2. Дундад зууны үеийн олон улсын эрх зүй (Ү зуунаас гучин жилийн дайны төгсгөл

¹ МУИС-ийн ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

хүртэл);

3. 1648 онд байгуулагдсан Вестфалийн энх тайвны гэрээ хүртэл үе:

- 1648 оноос 1815 оны Венийн конгресс хүртэл үе буюу Наполеоны дайны төгсгөл үе ч гэж үздэг;
- 1815 оноос 1919 оны Версалийн энх тайвны гэрээ байгуулж, Дэлхийн I дайн төгсгөл болсон үе хүртэл;
- 1919 оноос Дэлхийн II дайны төгсгөл болсон үе хүртэл;
- 1919 оноос Дэлхийн II дайны төгсгөл ба 1945 онд НҮБ байгуулагдах хүртэл үе.

4. Шинэ үеийн олон улсын эрх зүй.

Орчин үед НҮБ нь олон улсын эрх зүйн хөгжилд нөлөө бүхий байгууллага болсон бөгөөд түүний салбар байгууллагууд улс хоорондын харилцааны уур амьсгалыг тодорхойлох болжээ. Хүн төрөлхтний түүхийн үе болгон олон улсын эрх зүйн төлөвшилтөнд өөрийн гэсэн мөрөө үлдээж, хувь нэмэр оруулан баяжуулсан байна. Олон улсын эрх зүйн үүсэл, хөгжлийн үе шатны талаар олон янзын байр суурь, таамаглал байдаг. Оросын эрдэмтэн И.И.Лукашук (1926-2007) олон улсын эрх зүйн гарал үүслийн талаар гурван янзын таамаглал байдгийг дурдсан байдаг. Үүнд:

- Олон улсын эрх зүй төр, улс үүсэхээс өмнө овог аймгийн харилцааны үед бий болсон;
- Олон улсын эрх зүй төр улстай хамт үүссэн;
- Олон улсын эрх зүй Дундад зууны үед Европ тивд үүссэн.

Германы олон улсын эрх зүйч Лоуренс Оппенгейм (1858-1919) ХҮ-ХҮI зууны үед олон улсын эрх зүй үүссэн гэж үзжээ.

Оросын дипломат, олон улсын эрх зүйч Ф.Ф.Мартенс (1845-1909) олон улсын эрх зүйн түүхийг гурван үед хуваасан байна. Үүнд:

- Эртний үеэс ХҮII зууны дунд үе хүртэл;
- ХҮII зууны дунд үеэс XIX зууны эхэн үе хүртэл;
- 1915 оны Венийн хурлын үеэс орчин үе хүртэл.

Олон улсын эрх зүйн нэвтэрхий тольд олон улсын эрх зүйн үечлэлийг дараах байдлаар тогтоосон байдаг. Үүнд:

1. Эртний үе: МЭӨ 3000-400 он;
2. Эртний үеийн дундад зууны үе: 400-800 он;
3. Дунд үеийн дундад зууны үе: 800-1300 он;
4. Хожуу үеийн дундад зууны үе: 1300-1500 он;
5. Испаний эрин үе: 1500-1648 он;
6. 1648-1815 он;
7. 1815 оноос Дэлхийн I дайны үе хүртэл олон улсын эрх зүй;
8. Дэлхийн I ба II дайны хоорондох үеийн олон улсын эрх зүй;
9. Дэлхийн II дайны дараах үеийн олон улсын эрх зүй.

Олон улсын эрх зүйн хөгжлийг улс орнуудын хоорондын харилцаатай салшгүй холбоотой гэдгийг олон улсын эрх зүйн үечлэл харуулж байна.

Эртний үеийн олон улсын эрх зүй

МЭӨ IV зууны төгсгөл, III мянган жилийн эхэн үед анхны төр улс байгуулагдсан хэмээн түүхэн эх сурвалжид дурьдсан байдаг. Эдгээр улс орны хооронд үүссэн харилцааны үр дүнд эрх зүйн хэм хэмжээ үүссэн ч, олон улсын эрх зүйн систем бий болсон гэж үзэх эрт байв. Түүхийн баримтаас үзвэл улс гүрний хооронд дайныг зогсоох, гэрээ байгуулах, холбоотны харилцааны хэлбэрийг тодорхойлох зэрэг асуудлаар элч солилцон, хэлэлцээ хийдэг байжээ. Олон улсын эрх зүйн хөгжилд эрт үед ч, эдүгээ цагт ч дайн дажин үлэмж нөлөөлсөн. Үүнийг олон улсын харилцааны түүхээс харж болно.

Эрт үеийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг тодорхойлогч гол хүчин зүйл нь зан заншил байв. Овог аймаг төдийгүй анхны төр улсуудын хоорондын харилцааг зохицуулах үйл явцад чухал үүрэгтэй байсан учир олон зууны туршид олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалж нь зан заншил болж байсан. Заншлын зэрэгцээ эхэндээ аман гэрээ хийж тохиролцох үзэгдэл зонхилж байсан ч бичиг үсэг үүссэнээр олон улсын гэрээний эрх зүйн хөгжилд шинэ хуудас нээгдэж, бичмэл гэрээний хэлбэр бий болжээ. МЭӨ 2100 онд Өмнөд Мессопотамын (одоогийн Ирак улсын газар нутаг) Лагаш, Умма гэсэн хот улсын хооронд хил хязгаарын талаар байгуулсан гэрээ хэлцлийг сийлсэн чулуун хавтан нь хүн төрөлхтний түүхэнд бичиж үлдээсэн анхны эх сурвалж гэж үзэх үндэстэй. Уг бичвэрт гэрээг мөрдөж биелүүлэх баталгаа нь бурхан гэж үзсэн байна. Мөн гарсан маргааныг арбитрын үндсэн дээр шийддэг байсан ажээ.

МЭӨ 1296 онд (зарим эх сурвалжид 1269 он гэж бичсэн байдаг) Египетийн Фараон II Рамзес, III Хеттийн хаан Хаттушил нарын хооронд байгуулсан гэрээ нь түүхэнд алдаршсан байдаг. Гэрээ байгуулсан талуудын эзэмшил нутаг дэвсгэрт дайсан халдсан тохиолдолд харилцан нэг нэгэндээ цэрэг зэвсгийн туслалцаа үзүүлэн, эзэмшил нутагт бослого, самуун дэгдсэн үед хүч хавсран дарах, урвагчийг эд хөрөнгийн хамт эргүүлэн өгөх гэсэн зүйл анги багтсан байдаг ба баталгаа нь Египетийн болон Хеттийн бурхад хэмээн үзсэн байна. Гэрээг зөрчигч нь тэнгэр, бурхны хатуу цээрлэл хүлээх болно гэжээ. Эл гэрээг 17 жилийн дайныг зогсоох зорилгоор хийсэн анхны "энх тайвны тухай" гэрээ гэж үздэг.

МЭӨ анхны мянган жилд Ассири, Вавилон, Перс, Урарту улс Ойрхи Дорнодын олон улсын харилцаанд их нөлөөтэй, чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ. Тухайн үеийн гэрээнд голчлон дайн, газар нутаг эзлэн авах, татвар ногдуулах, цэргийн холбоо байгуулах, хааны залгамж холбоог бэхжүүлэх асуудал хөндөгдөж байв. Мөн энэ үед Эртний Хятад, Энэтхэг улс үүссэн. Түүхэн хөшөө дурсгал дээр Эртний Хятадын улсууд хоорондоо дипломат харилцаатай байж, олон улсын гэрээ тогтмол байгуулж байсан баримт хадгалагдан үлдсэн байдаг. Элч төлөөлөгчид халдашгүй дархан эрхтэй байж, олон улсын харилцааны асуудлыг шийдвэрлэхэд хаадын чуулганыг хийдэг байсан байна. Тухайлбал, МЭӨ VI зуунд хуралдсан чуулганаар маргаантай асуудлыг тайван замаар шийдвэрлэх ба хөндлөнгийн шүүхийн тухай гэрээ байгуулсан байдаг. Гадны халдлагаас хамгаалахын тулд цэргийн холбоо байгуулдаг байжээ.

Эртний Хятадын улсуудын дунд хөрш улсуудын аж ахуйд чухал үүрэгтэй гол мөрний эх булаг, урсгалыг өөрчлөхийг хориглодог байсан байна. Мөн Хятадын хаадуудын хооронд газар нутгийн маргаан их байсантай холбоотой өөр хоорондоо газар нутгийн асуудлаар

гэрээ хийж, түүнийгээ баталгаажуулах арга замыг эрэлхийлж байсны нэг жишээ бол хийсэн гэрээгээ баталгаажуулах үүднээс гэрээнд оролцогч үхрийн цусыг амандаа түрхэж гэрээгээ тамгалдаг байжээ. МЭӨ 546 онд Эртний Хятадын улсуудын хооронд үл довтлох анхны гэрээ хийгдэж байсан ба мөн ховор ан амьтдыг хамгаалах талаар гэрээ байгуулж байжээ.

Эртний Энэтхэгийн улсуудын хоорондын харилцаа төлөвшихөд Манугийн хууль ихээхэн нөлөө үзүүлсэн. Улс төр, гэрээ, аян дайн явуулах арга зам, олон улсын эрх зүйн асуудалтай холбоотой зүйл заалтууд уг хуульд тусгагдсан байдаг. Мөн эртний Энэтхэгийн улсууд элчин төлөөлөгч нарын халдашгүй дархан эрхийг хүлээн зөвшөөрч байв. Энхийн ба дайны үеийн гэж гэрээг хоёр ангилан, олон улсын гэрээнд ихээхэн ач холбогдол өгч байжээ. Гэрээнд оролцогч талууд зохих үндэслэл гаргаж чадвал гэрээг биелүүлэхгүй байж болно хэмээн үздэг байв. Түүнчлэн дайн хийх дүрэм журамд онцгой анхаарсан байдаг. Манугийн хуульд шударга, шударга бус дайны талаар номлоод, хордуулсан зэвсэг ашиглах, хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд, лам санваартан, олзлогдогсдыг алахыг хориглосон ба шархдагсдыг чөлөөлж явуулах заалт байв.

МЭӨ VIII-VI зуунд хамгийн анхны хот улсууд Газар Дундын Тэнгис, Балканы хойгийн орчим бий болсон. Тухайлбал, Эртний Грекийн хот улсууд болох Коринф, Мегар, Фив, Спарта, Трой, Афин, Эртний Ром зэргийг дурдаж болно. Эртний Грект зөвхөн грекийн төр улсууд, түүний эзэмшил газарт эрх эдэлнэ хэмээн тунхагласан байдаг нь зөвхөн грекүүд бүрэн эрхтэй иргэн гэж тооцогдож байсныг гэрчилнэ. Харин грек бус хүмүүсийг "гадаадын харьяат" гэж үзэж байжээ.

Эртний Грекийн улс орнуудын хооронд харилцааны олон хэлбэр байв. Эдгээр харилцааг тусгай хэл хүргэгч хэрэгжүүлж байсан ба хожим элч төлөөлөгчдийг илгээх замаар уг харилцааг хэрэгжүүлэх болжээ. Элч төлөөлөгчдийн газрын тэргүүн нь элчин төлөөлөгч байх ба түүнд итгэмжлэх диплом олгодог байсан. Уг диплом нь зорж сийлсэн хоёр модон хавтас байв. Эндээс "дипломат" гэдэг нэр томъёо гарсан ажээ. Элч төлөөлөгч нь Бурхны ивээлд байж, халдашгүй дархан эрхтэй хэмээн үзэж байв. Энэ үед энх тайвны, холбоотны, арбитрайн, гадаадын харьяат албатын тухай гэсэн олон янзын гэрээ хийдэг байжээ. Мөн гэрээг заавал биелүүлэхээ илэрхийлж тангараг өргөдөг байсан ба зарим тохиолдолд хүнийг ч барьцаа болгодог байв.

Эртний Грекийн хот улсад гадаадын иргэд ямар ч эрхгүй байснаас проксений (Зочломтгой зан-гадны элч төлөөлөгчийг хүлээж авах баяр ёслол гэсэн байгууллага үүсчээ) салбар бий болсон. Проксенээр Грекийн ямар нэгэн иргэнийг томилдог ба гадаадын иргэдийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй байв. Үүний хажуугаар проксен нь гадаадын улсын эрх ашгийг хамгаалдаг байсан ба тухайн улс болон өөрийнхөө хот улсын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байжээ. Энэ нь орчин үеийн олон улсын эрх зүйн консулын эрх зүйн салбарын эхлэл болсон байна.

Грекийн хот улсууд аян дайнтай холбоотой тодорхой дүрэм боловсруулжээ. Уг чанартаа эдгээр дүрэм нь цаашдаа олон улсын эрх зүйн хэм хэмжээ болсон юм. Тухайлбал, дайныг заавал зарлаж байж явуулах ёстой ба хордуулсан зэр зэвсэг хэрэглэхгүй гэсэн заалт түүнд тусгагдсан байдаг. Үүний зэрэгцээ, эзлэгдсэн хотын хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөх нь гэмт хэрэг хэмээн үздэг байв. Олзлогдсон цэргүүдийг хэрхэх тухай

дүрэм үйлчлэн, олзлогдогсдыг нэг бол шууд алах эсхүл боол болгодог байжээ. Сүм хийдэд хоргодсон хүмүүсийг алахыг хориглосон, шарилыг хөндөх болон шүтээн бузарлахыг цээрлэх зэрэг тодорхой хориглох зүйл тухайн дүрэмд тусгагдсан байдаг. Мөн амь үрэгдсэн дайсны цэргийг оршуулахыг зөвшөөрдөг байжээ. Грекийн хот улсууд хоорондоо дайтаж буй нөхцөлд грекчүүд нийтийн цэнгээний газар, сүм хийдэд чөлөөтэй орох эрхтэй ба өргөл барьц өгөх боломжтой байв.

Эртний Грект дайтахад онцгой шалтгаан байх ёстой байсан. Дайныг хууль ёсны ба хууль бус гэж ангилаад өөрийгөө хамгаалах дайныг хууль ёсны, холбоотны өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн дайныг хууль бус гэж үздэг байв.

Эртний Грект хөндлөнгийн шүүхийн оролцоотой маргааныг шийдвэрлэдэг байжээ. Ихэвчлэн симмах (цэрэг улс төрийн нэгдэл) хөндлөнгийн шүүхийн үүргийг гүйцэтгэж байв. Хөндлөнгийн шүүх нь дайны төгсгөл, хилийн маргаан ба бусад асуудлыг шийдвэрлэдэг байжээ. Аристотель, Геродот, Ксенофонт, Платон, Плутарх зэрэг эртний Грекийн их сэтгэгч, түүхчдийн бүтээлд олон улсын эрх зүйн зарим асуудлын талаар дурьдсан байдаг. Үүнд, дайны тухай, олзлогсдын эрх зүйн байдал, грекийн иргэд болон зэрлэгүүдийн хоорондын харилцааны тухай гэх мэт.

Грекийн хот улсууд хоорондоо хоёр төрлийн холбоо байгуулдаг байжээ.

1) Шашин ба улс төрийн холбоо. Жишээ нь: Дельфий-Фермопилийн амфитони. (Амфитони-эртний холбоотон хотуудын шүүхийн дүрэм).

2) Цэрэг-улс төрийн холбоо. Жишээ нь: Лакедемон ба Афины симмарх, Этолийн ба Ахейсийн холбоо.

Эдгээр холбоо нь орчин үеийн олон улсын байгууллагын эхлэл суурь болсон гэж үзэж болно. Холбоод нь байнгын үйл ажиллагаатай ба дээд байгууллагуудтай байв. Холбооны гишүүдийн нэр хүнд, нөлөөнөөс үл хамааран гишүүн бүр нэг санал өгөх эрхтэй байсан бөгөөд олонхийн саналаар шийдвэр гаргадаг байжээ.

Эртний Ромд бусад улс оронтой харилцах шашны тусгай алба ажилладаг байсан байна. Тэд дайн зарлах, энхийн гэрээ байгуулах, холбоотны гэрээ байгуулах, олон улсын гэрээг хамгаалах, гадаад улсад шаардлага тулгах зэрэг үүрэгтэй байв. Эрх зүй ба шашин хоёр нь хамтран үйлчилдэг байсан. Ромчуудын хийсэн дайныг, мөн зарласан дайныг шударга дайнд тооцож байжээ. Фециалчууд буюу бөө тайлагч нар дайн зарлах ажлыг зохион байгуулж явуулдаг байжээ. Эртний Ромын амбан, түшмэд олон улсын харилцаанд оролцох, дайн байлдааныг зарлан явуулах ба энх тайвны гэрээг байгуулах үүрэгтэй байв. Дайн хийх явцад ромчуудад хориглох зүйл байсангүй. Эзлэгдсэн хот, иргэд тэдний өмч хөрөнгийг дайны хууль ёсны олз гэж үзэн олзлогдсдыг алж, боол болгодог байсан хэдий ч Ромчууд хордуулсан зэвсэг ашиглах ёсгүй гэж үздэг байжээ. Өөрийн тусгай төлөөлөгчөөр дамжуулан эртний Ром гадаад улс оронтой харилцаж байв. Элч төлөөлөгч гэрээ хэлэлцээр хийх, гэрээнд гарын үсэг зурах, маргааныг арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх, найрамдлын гэрээ байгуулах зэрэг үүрэгтэй байв. Ромчууд гадаадын болон дайтагч улсын элч төлөөлөгчдийн халдашгүй дархан эрхийг хүлээн зөвшөөрч байжээ.

Ромын эрх зүйн сургаал, номлол баялаг түүхтэй ч олон улсын эрх зүйн нэгээхэн хэсэг асуудлыг л тусгасан байдаг. Эртний Ромын улс төрийн зүтгэлтэн, философич

Цицерон зарласан дайныг шударга гэж үзэж байв. Эртний Ромын хуульч Ульпиан ард түмэн нутаг дэвсгэр дээрээ эдэлбэл зохих эрхийн тухай бичсэн байдаг. Үүнд, газар нутгаа баталгаажуулах, нутаг дэвсгэр дээрээ бүтээн байгуулалт өрнүүлэх, дайн хийх, боолчлох, бусад улстай энхийн гэрээ байгуулах ба найрамдах, гадны элчийг хамгаалах, амь насанд нь халдах, элч төлөөлөгчийг доромжилж болохгүй г.м.

Ромын нутаг дэвсгэр дээр оршин суух гадаадын иргэн ямар ч эрх эдэлдэггүй байсан. Тэд боол болох, эд хөрөнгөө алдах эрсдэлтэй байв. Найрамдлын гэрээ байгуулсан нөхөрсөг улс орны иргэд үүнд хамаарахгүй байжээ.

Эртний Ромд Эртний Гректэй нэгэн адил гадаадын иргэдийг хамгаалах байгууллага бий болов. Гадаадын иргэдийн оролцоотой асуудлыг хариуцсан тусгай төлөөлөгчид байв. Эртний Ромын дээд шүүгч, амбан түшмэд гадаадынхны эрхийг тодорхойлсон дүрэм боловсруулсан ба чухамхүү энэ үед "ард түмний эрхийн" тухай ойлголт бий болсон ажээ. Гадаадынхан Ромчуудтай адил эрх эдэлдэг болсон. Эндээс Ромын эрх зүйн үүсэл хөгжлийн үед Европт бий болсон "ард түмний эрх" гэсэн ойлголт нь "олон улсын эрх зүй" гэсэн ойлголтыг бий болгожээ.

Хууль зүйн шинжлэх ухаан, олон улсын эрх зүйн цаашдын хөгжилд Ромын эрх зүй их хувь нэмэр оруулсан. Эртний Грекийн "хатуу ширүүн амьдралын хэв маягаараа онцлог философийн сургуулийн төлөөлөгчдийн" нөлөөгөөр Ромын хуульчид жам ёсны эрхийн үзэл санааг хөгжүүлж, хүн бүр, бүх ард түмэн жам ёсны эрх эдлэх учиртай гэж үзсэн нь олон улсын эрх зүйн шинжлэх ухаанд тусгалаа олсон байна. Мөн олон улсын эрх зүйн хөгжилд Эртний Грек, Ромын эрх зүйн сургаал их хувь нэмэр оруулсан гэж түүхчид үздэг.

Дундад зууны үеийн олон улсын эрх зүй

476 онд Баруун Ромын эзэнт гүрэн задран унах явцад Европт төр улсууд байгуулагдах үйл явц эхэлж, IX зуун хүртэл үргэлжилсэн ба XVI-XVII зуун хүртэл феодалын задралын үе өрнөж, үүний үр дүнд хэмжээгүй эрхт хаант засаглал тогтсон ажээ. Ромын эзэнт гүрний газар нутагт Европын улсуудаас гадна Ойрхи болон Дундад Дорнодод Арабын Халифат үүссэн. Мөн VII зуунд Болгарын анхны хаант улс (Славын улс орнууд), VIII зуунд Венецийн хот улс, VIII-IX зуунд Эртний Орос улс, VIII-X зуунд Польш улс, X зуунд Генуя, Пиза, IX-X зуунд Герман, Англи, XI-XIV зуунд Сельжукийн хаант улс, Османы эзэнт гүрэн (Османы эзэнт гүрэн ба Түргийн улсын үүсэж байсан үе), XIII зуунд Монголын эзэнт гүрэн бүрэлдэн олон улсын харилцааны шинэ оролцогчид болов.

Дундад зуунд дайн тулаан тасраагүй ч төр улс, төрт ёсыг төлөвшүүлэх үйл явц эрчимтэй явагдаж байв. Улс орнуудын хооронд найрамдлын болон худалдааны гэрээ хийгдэж, үүнээс хамааран олон улсын эрх зүйн салбарууд, дэд салбарууд үүсэх шаардлага гарсан.

Европд загалмайтны шашны нөлөө хүчтэй байсан бөгөөд загалмайтнууд Европын улсуудыг оюун санааны хувьд нэгтгэн, тэр үеийн олон улсын харилцааны ширүүн уур амьсгалыг зөөллөж, зоргоор аашлах үйл ажиллагааг хязгаарлаж байв. Католик сүм хийдийн удирдлага зөвхөн шашны төдийгүй мөн нийгмийн болон олон улсын эрх зүйд хамаарах асуудлыг шийдвэрлэж байжээ.

XII зуунд Ромын эрх зүй эрчимтэй хөгжиж байсан энэ үед Библи судар, сүм хийдийн гаргасан баримт бичиг нь олон улсын харилцаанд улс орны эзлэх байр суурийг тодорхойлж байсан

шиг Ромын эрх зүй ч мөн адил чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Гэрээний эрх зүй ба газар нутгийг эзэмших арга зам зэрэг олон улсын эрх зүйн хэд хэдэн салбарын хөгжилд чухамхүү Ромын эрх зүй чухал нөлөө үзүүлсэн байна. Ромын эрх зүй иргэний шинжтэй байсан тул түүний нөлөөн доор төлөвшиж байсан олон улсын эрх зүйн салбар нь соёл, иргэншлийн өнгө аястай болж эхэлсэн байна.

XV зуунаас байнгын үйл ажиллагаатай дипломат төлөөлөгчийн газар байгуулагдаж эхэлсэн. Урьдын адил элч төлөөлөгч халдашгүй дархан эрхтэй байв. Мөн дипломат төлөөлөгч, түүний орон байранд халдашгүй дархан эрхийн зарчим үйлчилж эхэлсэн. Уг зарчмыг бэхжүүлэхэд сүм хийд их үүрэг гүйцэтгэж байсан ба элч нар нь сүм хийдийн ивээлд багтдаг гэж үздэг байв. Энэ үед элчингийн дэв зэргийн асуудал чухлаар тавигдсан.

XIII зуунаас Италийн хот улсуудын колони болох худалдааны газруудад консулууд суух болсон. Тэд өөрийн улсын иргэд хоорондын маргааныг шийдвэрлэх, гадаадад оршин суугаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах үүрэгтэй байжээ. Эл үед гадаадын иргэд ямар ч эрх эдэлдэггүй байв. Феодлын газар нутаг дээр тусгай зөвшөөрөлгүй болон нэг жилээс илүү оршин суурьшсан аливаа гадаадын иргэдийг хамжлагат болгон эд хөрөнгө нь газар өмчлөгч феодлын эзэмшилд очдог байв.

Тухайн цаг үед далайн эрэг орчмын газар нутгийг эзэмших эрхийн асуудал гарч ирсэн байна. Далайн эрэг орчмыг эзэмшигчийн газар нутаг дээр далайн усан онгоц сүйрсэн тохиолдолд амьд гарсан хүмүүс болон тэдгээрийн өмч хөрөнгө, эд зүйлсийг газрын эзэн өөрийн болгон авах эрх эдэлж байжээ. Энэ үеэс олон улсын гэрээнд гадаадын иргэдийн эрхийг хамгаалах зорилгоор дээрх заалтыг тусгаж эхэлсэн.

XVI зуунаас Европын улсууд Исламын орнуудтай "бууж өгөх журмын" тухай гэрээг байгуулж эхэлсэн. Татвар, хурамж төлөх, хэрэг шүүх үйл ажиллагаанд зөвхөн европчууд хөнгөлөлт эдлэхээр уг гэрээнд тусгасан байна.

Энэ үед олон улсын гэрээний эрх зүй эрчимтэй хөгжиж байв. Зөвхөн дайны төгсгөл болон газар нутгийг шилжүүлэн өгөх асуудлаар гэрээ хийгээд зогсохгүй олон улсын худалдааны болон хаадын харилцаа холбоог бэхжүүлэн хөгжүүлэх гэрээ олноор хийгдсэн. Мөн олон улсын гэрээний биелэлтэд улс орнууд онцгой анхаарал тавих болсон байна. Тухайлбал, Христосын өмнө Евангел судар барин, шашны ёслол үйлдэн тангараг тавьж, гэрээ зөрчигчийг сүм хийдээс тусгаарлан, тодорхой газар нутагт мөргөл үйлдэж, шашны зан үйл, ёслол хийхийг түр болон бүрмөсөн хориглох шийтгэл хүлээлгэж байв. Шийтгэх эрх мэдэл Ромын хамба ламд байсан. Зарим тохиолдолд шашны тангараг хангалтгүй бол төрөөс нэмэлт баталгаа гаргах арга хэмжээ авдаг байв. Ийм баталгааг ихэвчлэн Ромын хамба лам, Ромын эзэнт гүрний хаан гаргаж өгдөг байсан. Мөн үнэт зүйлс, газар нутаг, хүн барьцаалан баталгаа гаргаж өгдөг байжээ.

Усан онгоцны үйлдвэрлэл хөгжиж, далай тэнгисийг өргөн ашиглах болсон нь олон улсын харилцааны хөгжилд төдийгүй мөн олон улсын эрх зүйн хөгжилд ч ихээхэн нөлөөлсөн. Дундад зууны үед улс орон өөрийн эрэг орчмын далай тэнгисийн орон зайг эзэмших санаархалтай байв. Тухайлбал, Венец Адриатын тэнгисийг, Генуя, Пиза Лигурийн тэнгисийг, Англичууд өөрийн эрэг орчмын усыг өөрийн мэдэлд оруулах оролдлого тус тус хийцгээж байв.

ХҮ-ХҮІ зуунд газар зүйн томоохон нээлтүүд хийгдсэн нь далай тэнгисийн ихээхэн орон зайг эзэмших гэсэн санаархлыг хүчирхэг гүрэн болох Испани, Португальд төрүүлсэн байна. Энэ нь цэргийн мөргөлдөөнд хүргэн, дайтах аюул нүүрлэсэн учир Ромын хамба лам ҮІ Александр 1493 онд Атлантын далайг Испани, Португальд хуваан эзэмшүүлэх шийдвэр гаргажээ. Дараа нь эдгээр улс 1494, 1529 онуудад Атлант, Номхон далай, Энэтхэгийн далай, түүний эрэг орчмын газрыг хуваан эзэмших тохиролцоонд хүрсэн байна. Үүнийг бусад улс орон хүлээн зөвшөөрөхгүй байсан бөгөөд ХҮІ зууны эцэс ХҮІІ зууны эхэн үед Англи, Нидерланд улсууд далай тэнгисийг чөлөөлөхийн төлөө хүч чармайлт тавих болжээ.

Голландын хуульч Гуго де Груйт 1609 онд бичсэн "The Free Sea" зохиолдоо "нээлттэй далайг чөлөөтэй болгох" зарчмыг онолын үндэслэлтэй болгожээ. Мөн эрэг орчмын сав газрын усыг улс орнууд эзэмших эрхийн талаар тайлбар хийсэн байдаг.

Далай тэнгисийг ашиглахтай холбоотой үүссэн улс хоорондын харилцааг зохицуулах хэм хэмжээ олон улсын эрх зүйд тусгалаа олсон байна. Эдгээр хэм хэмжээ нь эрэг орчмын болон задгай далайн орон зайд усан онгоцны эзний эдлэх эрхийг тодорхойлсон төдийгүй мөн усан боомтын үйл ажиллагааг зохицуулах зорилготой байсан. Родосын эрх зүй, Олероний хуйлмал бичиг, Консолато дель Маре, Висбийн хуулиуд зэрэг далайн ёс заншлын эмхтгэл боомтын эрх зүйг төлөвшихөд нөлөө үзүүлсэн байна.

Дундад зуунд дайныг жам ёсны зүйл хэмээн үзэж, олон арга замаар дайн хийдэг байжээ. Энэ үед эзлэгдсэн хот суурин газрыг тонон дээрэмддэг байсан ба ялагч улс ялагдагч талын бүх эд хөрөнгийг өөрийн мэдэлд шилжүүлдэг байв. Гэсэн хэдий ч тодорхой зан заншлыг дагаж мөрдөх явдал улс орнуудад байсан байна. Тухайлбал, дайн хийхэд тодорхой шалтгаан байх ёстой ба түүнийгээ тайлбарлаж албан ёсоор зарладаг байж. Дайныг хууль ёсны ба хууль бус гэж ялгаж, зарласан дайныг хууль ёсных хэмээн үздэг байв.

Сүм хийдийн чуулганаар зэр зэвсгийн наймаа, цэрэг дайны үйл ажиллагаа явуулах арга хэрэгсэл, түүнийг хязгаарлах талаар тогтоол гаргах болсон байна. 1139 онд болсон Латераны чуулган дээр сүм хийдээс хөөх гэсэн шийтгэлээр далайлган дайн тулаанд арбалет-нум сум хэрэглэх, мөн мусульманчуудад усан онгоц, зэвсэг зарахыг хориглосон шийдвэр гаргаж байв. Харин дайтагч талын олзлогдогсод, шархдагсдыг хороохыг хориглоогүй ажээ. Хожим нь зэвсэггүй, өршөөл гуйсан хүнийг алахыг хориглосон зүйл заалт бий болсон байна. Хэдийгээр Европын орнуудад боолчлол байгаагүй ч аажимдаа олзлогдсон цэргийн төлөөсийг авдаг ёс бий болжээ.

Далайн худалдаа эрчимтэй хөгжсөнөөр тэнгис далайд цэрэг дайны үйл ажиллагаа явуулах тусгай хэм хэмжээ бий болох нөхцөл бүрэлдсэн байна. ХІІІ-ХІҮ зуунд каперийн салбар үүссэн. Энэ нь хувийн хөлөг онгоц эзэмшигч төрөөс тусгай гэрчилгээ авсан тохиолдолд дайсны усан онгоц болон түүн дээр буй эд хөрөнгийг булаан авах эрхтэй болж, өөрийн болгосон зүйлийг "бай шагнал" гэж нэрийдэх болсон.

Дундад зуунд зуучлал, арбитр зэрэг олон улсын маргааныг тайван замаар шийдвэрлэх арга хэрэгсэл хөгжиж эхэлсэн. Хөндлөнгийн шүүхийн тухай тусгай гэрээг байгуулдаг болсон. Тухайн үед олон улсын эрх зүйн бие даасан шинжлэх ухаан хараахан бүрэлдэн тогтож амжаагүй байсан хэдий ч шашны номлогч, философич, хуульчдын бүтээлд олон улсын эрх зүйн асуудлаар дэвшүүлсэн үзэл санаа багагүй байдаг. Тухайлбал, 345-430

онд амьдарч байсан Ариун хутагт Августины бичсэн "City of God" зохиол тэр үеийн эрдэмтэн мэргэдэд их нөлөө үзүүлсэн юм. Уг бүтээлд олон улсын гэрээг дагаж мөрдөх зайлшгүй шаардлагатай болохыг дурдсан байдаг. Мөн тэрээр дайныг шударга, шударга бус гэж ангилаад, зөвхөн хууль зүйн үндэслэлтэй гарсан дайныг шударгад тооцно гэжээ. Тухайлбал, өөрийн улсаа гадны түрэмгийллээс хамгаалан хариу үйлдэл хийх шаардлагаас үүдсэн дайныг шударга гэж үздэг байв.

Мөн XIII зууны шашны нэрт зүтгэлтэн Аквины Фома (1225-1275) дайныг шударга, шударга бус гэж ангилж байжээ. Гэрээний заалтыг дагаж мөрдөөгүйгээс шударга дайн гарах шалтаан болно гэжээ. Түүний дэвшүүлсэн үзэл санаа эрх зүйн номлол, олон улсын эрх зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан гэж судлаачид үздэг. Жам ёсны эрхийн талаарх сургаалийн эхийг тавьсан хэмээн Фомаг үнэлдэг.

Дайны хуулийн тухай Италийн эрдэмтэн Жованни да Легнано 1360 онд "De Bello, De Represaliis et De Duello" бүтээлээ, Францын эрдэмтэн Оноре Боне 1385 онд "Tree of Battle" номоо бичсэн байна.

Олон улсын эрх зүйн үзэл санааг хөгжүүлэхэд XIV зууны Италийн хуульч Бальд (1327-1400), Бартол (1314-1357) нар ихээхэн хувь нэмэр оруулсан. Тэд хааны байгуулсан олон улсын гэрээ хууль ёсных байх уу, үгүй юу гэдэг асуудлыг хөндөж байсан нь сонирхолтой юм.

XVI зуунаас эхлэн эрдэмтэд олон улсын эрх зүйн асуудалд илүү анхаарах болсон. Испаний шашны номлогч Ф.Витори тэр үеийн Испаний улс төрчдийн үйл ажиллагаа, бодлогыг шүүмжлэн, Америкийн уугуул индианчуудыг хууль ёсны эрх ашигтай байх эрхтэй ард түмэн гэж үзэж байв. Индианчуудтай хийж буй испанчуудын дайн хүндэтгэх шалтгаантай бол шударга дайнд тооцогдох болно гэжээ. Өөрөөр хэлбэл, испанчуудын хийж буй дайныг шударга бус дайнд тооцсон байна. Мөн тэрээр олон улсын эрх зүй нь жам ёсны эрхийн нэг хэсэг тул Европ тивээс гадна амьдардаг ард түмэн ч гэсэн дээрх эрхийг эдлэх учиртай гэжээ.

Олон улсын эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд жинтэй нөлөө үзүүлсэн эрдэмтний нэг бол А.Жентили (1552-1608). Түүний 1585 оны "Three Book of Embassies", 1598 оны "Three Books on The Law of War" зэрэг бүтээлүүд нь олон улсын эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан. Тэрээр зөвхөн хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд шударга дайн хийх ёстой гэсэн байдаг. Гэмт хэрэгт холбогдсон гадны улсын элчин төлөөлөгчийг хэрэгтнээр татаж болох боловч улсын эрх ашгийн үүднээс түүнийг тухайн орноос хөөн гаргах нь зүйтэй гэж үзсэн байдаг нь хожим орчин үеийн дипломат ба консулын харилцааны эрх зүйн чухал зарчим болсон юм.

Олон улсын практикт улсын бүрэн эрх ба тэгш эрхийн үзэл санаа аажим нэвтрэх болсон. Тухайлбал, XV-XVI зууны үеийн эрдэмтэд болох Н.Макиавелли (1469-1527), Т.Гоббс (1588-1679) нар бүтээлдээ энэ тухай тусгасан байдаг. Мөн 1576 онд хэвлэгдсэн "The Six Books of The Commonwealth" бүтээлдээ Ж.Боден бүрэн эрхийн талаар үзэл бодол дэвшүүлэн түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй болгосон. Хааны бүрэн эрх нь туйлын бөгөөд байнгын шинжтэй байна гэж тэрээр үзжээ. Төр улсын бүх иргэн, албан газрыг хамран үйлчлэх хууль батлах, дайн ба энхийн асуудлыг шийдвэрлэх, албан тушаалтныг

томилох, дээд шүүхийн үүргийн тухай, өршөөл үзүүлэх зэргээр улсын бүрэн эрх илэрдэг гэжээ. "Бүрэн эрхийн тухай" ойлголт ХҮИ зуунд олон улсын эрх зүйд тусгалаа олсон. Энэ үеээс л бүрэн эрх нь улсын хууль зүйн чухал шинж тэмдэг болсон байна.

Гуго де Грүүт (1583-1654) олон улсын эрх зүйн үндсэн асуудлыг нарийн судалсан эрдэмтэн бөгөөд 1625 онд гурван ботиос бүрдсэн "The Rights of War and Peace" бүтээлээ хэвлүүлсэн. Тэдгээрийг олон улсын эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд ач холбогдолтой бүтээл болсон гэж судлаачид үнэлсэн байдаг. Тэрээр олон улсын эрх зүйн чухал эх сурвалж нь улс хооронд хийгдсэн гэрээ, зан заншилд тулгуурласан зөвшилцөл хэмээн үзсэн байдаг. Үүний зэрэгцээ Гуго де Грүүт олон улсын эрх зүйн үндэс нь байгалийн болон Бурханы хууль гэж үзсэн байна.

Дундад зууны үед улс орнуудын хооронд энх тайвны, холбоотны, худалдааны болон өөр бусад гэрээнүүд латин хэлээр хийгддэг байсан. Энэ үеийн онцлог бол гэрээ хэлэлцээрүүд зөвхөн хэмжээгүй эрхт хаадуудын дунд хийгдэж байсан нь олон улсын харилцаа хувийн шинжтэй байсанд оршино.

1648-1815 оны үеийн олон улсын эрх зүй

Европт шашны асуудлаас үүдсэн дайн гучин жил үргэлжилсний эцэст 1648 онд төгсөж, Вестфалийн энхийн гэрээ байгуулагдсан. 1648 оны 10-р сарын 24-нд байгуулсан Вестфалийн гэрээ нь Оснабрюк, Мюнстерийн гэсэн хоёр гэрээнээс бүтдэг. Оснабрюкийн гэрээнд Ромын эзэн хаан холбоотны хамт нэг талаас, нөгөө талаас Швед улс холбоотны хамт гарын үсэг зурсан байдаг. Мюнстерийн гэрээнд Ромын эзэн хаан, Франц улс холбоотнуудтайгаа батламжилсан гарын үсэг зурсан байна. Уг хоёр гэрээ нь Европын улсууд хамтран Германыг ялсны үр дүнд бий болсон юм. Гэрээний дагуу Европын улсууд тэгш эрх эдэлж, улс гүрэн өөрийн газар, нутаг дэвсгэр дээрээ дээд эрхийг хэрэгжүүлэх ба түүний бүрэн эрхийг бусад улсууд нь хүлээн зөвшөөрөх ёстой болсон. Сэргэн мандалтын үе эхлэн Франц улс нь Лотарингийн нэг хэсгийг ба Эльзасийг бүхлээр нь өөртөө нэгтгэсэн. Энэ үед Швейцарь улс Нидерландын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн. Гэрээний үр дүнд Германы 355 улс тусгаар тогтнолоо олж бие биенийнхээ эрх ашигт хор хөнөөл учруулсан гэрээ хэлэлцээр хийхгүй байх үүрэг хүлээцгээжээ.

Олон улсын харилцааны зарим асуудлыг дээрх гэрээгээр зохицуулсан нь олон улсын эрх зүйн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн юм. Анх удаа улс төрийн тэнцвэртэй байдлын тогтолцоо бий болсон байна. Гэрээний дагуу Европын орнуудын тогтвортой холбоог үүсгэсэн. Гэрээ зөрчигч орны эсрэг шударга дайн хийж болно гэсэн зүйл заалт орсон байна. Түүнчлэн католик, протестант шашныг адил тэгш шүтэх боломжтойг уг гэрээнд тусгасан нь ихээхэн дэвшилттэй зүйл байв. Учир нь 1555 онд байгуулсан Аугсбургийн гэрээгээр эзэн хааныхаа шүтэн биширдэг шашныг албат иргэд нь даган шүтэх ёстой байв.

Гэрээ зөрчсөнөөс үүдэн гарсан дайныг хязгаарлах зүйл заалтыг Вестфалийн гэрээ агуулж байв. Заргалдаж буй талууд гурван жилийн турш маргаанаа тайван, шүүн хэлэлцэх арга замаар шийдвэрлэх оролдлого хийгээд бүтэлгүйтсэн тохиолдолд хохирогч тал дайн зарлах эрхтэй байв. Гэсэн ч энэ зүйл заалт огт хэрэгжиж байгаагүйг дурдах ёстой. Ялагч гүрнүүд болох Франц, Швед нь Вестфалийн гэрээний гол батлан даагчид болсон.

Вестфалийн гэрээ болон Өрнөд Европын соёл иргэншил нь "Сонгодог олон улсын эрх зүйн" үндсийг тавьсан болно. Вестфалийн гэрээний үр дүнд XVII-XVIII зуунд олон улсын эрх зүйн хэм хэмжээ шинээр бүрэлдэн бий болсон байна. Өмнө нь үйлчилж байсан олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүд тодорхой хэмжээгээр өөрчлөгдөн боловсронгуй болсон.

Төр хэнээс ч үл хамааран бие даан засаглалаа хэрэгжүүлэх ба эрх мэдэлтэй байх гэсэн ойлголттой нягт уялдан гарч ирсэн улсын бүрэн ба тэгш эрхийн үзэл санаан дээр үндэслэн олон улсын эрх зүй хөгжиж ирсэн гэж үзэж болно. Улс хоорондын тэгш эрх, тусгаар тогтнол, бүр эрхт байдлын үзэл санаанд тулгуурлан энэ үеийн олон улсын эрх зүй хөгжиж байсан. Гэсэн хэдий ч тэгш эрх нь тэр болгон хүлээн зөвшөөрөгдөж байсангүй. Тухайлбал, ямар улс орныг төлөөлж байгаагаас шалтгаалан элчин сайдыг хүлээж авах хүндэтгэл ялгаатай байсан байна. Английн төрийн ордонд Франц, Испаний элчин сайд нар өөрсөддөө илүү өндөр тусгай хүндэтгэл үзүүлэхийг шаарддаг байв.

Орчин үеийн дипломат харилцааны эрх зүйг энэ үед "элчингийн эрх зүй" гэдэг байжээ. Элчингийн эрх зүйд элчин сайд ба түүний орон байр халдашгүй дархан байх тухай хэм хэмжээ бий болсон. Өр зээл тавьсан болон ба гэмт хэрэгт холбогдсон элчин сайд хүлээн авагч улсын шүүхээр шүүгдэхгүй байх эрхтэй байв.

Олон улсын худалдааны өсөлт хийгээд түүний улс орнуудын дотоодын эдийн засагт үзүүлэх нөлөө нь консулын үүргийг өсгөсөн. Худалдаачид эсхүл хүндэт иргэдээс консулыг сонгодог байсан тогтолцоог өөрчлөн консулын газрыг төрийн алба болгон, төрөөстомилдог болжээ. Олон улсын гэрээнд консулын эрх зүйн байдал түүний үүргийг тодорхойлсон хэм хэмжээ олноор батлагдах болсон байна. Энэ үед батлагдсан худалдааны болон далайд зорчих тухай гэрээнүүдэд гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг тусгах болсон. XV зуунд бий болсон гадаадын иргэдийг нэн тааламжтай нөхцлөөр хангах тухай зарчим нь XVIII зуунд гэрээний практикт өргөн ашиглагдаж эхлэв. Гэрээнд оролцогч улсуудын иргэдэд эдлүүлэх хөнгөлөлт гуравдагч улсуудын иргэдтэй адил болсон байна.

Цессийн гэрээний үндсэн дээр газар нутаг олж авах үйл явц өрнөж, үүнд газар нутгийг солилцох, худалдаж авах, арилжих, бэлэглэх зэрэг арга хэлбэрийг өргөн ашиглаж байлаа.

Колончлолын бодлого нь хэн анх түрүүн, хэний ч биш газрыг эзлэн авна, тэр тухайн газар нутаг дээр бүрэн эрхээ эдлэх болно гэсэн эрх зүйн салбарын хэм хэмжээг тухайн үед бий болгосон ажээ. Тэнгис далайг эзэмших үйл явцад гарсан ололт шинэ газар нутгийн төлөөх тэмцлийг идэвхжүүлсэн ба далайн орон зайн тухай олон улсын эрх зүйн шинэ салбарыг бий болгоход хүргэсэн.

"Нутаг дэвсгэрийн далай" гэсэн нэр томъёо XVIII зуунд бий болсон бөгөөд уг ойлголтыг хожим нь олон оронд бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн билээ. Их бууны сум тусах хэмжээ буюу гурван миль орчим эргийн "нутаг дэвсгэрийн далайн орон зайг" улс орон эзэмших эрхтэй болсон. Тухайн хэмжээ XVIII зуунд өөрчлөгдөөгүй тул хойшид ч уламжлагдан үлджээ. Нээлттэй далай нийтийн эзэмшилд байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн нь нээлттэй далайн чөлөөт бүсийн зарчмыг бэхжүүлсэн байна.

Дайн хийх арга ажиллагаа хэрцгий хэвээр байв. Хөлсний цэрэг, арми үүссэнээр дайны үйл ажиллагаа улам харгис, хэрцгий шинжтэй болсон байна. Дайтагч талууд энгийн ард иргэд болон цэрэг дайчдыг ялгаж салгаж үздэггүй байв. Олзлогдогсдоор хүнд хүчир ажил

хийлгэдэг байжээ. Гэсэн хэдий ч ХҮШ зууны дунд үеэс цэргийн эмнэлэгт халдахгүй байх ба шархдагсдад тусламж үзүүлэх, жирийн ард иргэдэд халдахгүй байх талаар гэрээ хэлцэл хийгдэх болсон байна.

ХҮШ зуунд "эвсэлд үл нэгдэх" тухай ойлголт бий болсноор дайнд бүрэн оролцохгүй, оролцож буй талуудад тусламж үзүүлэхгүй байх байр суурийг улс орнууд баримтлах боломжтой болсон. Дайны явцад төрөөс зөвшөөрөл авсан тохиолдолд далайн дээрэм тонуул хийж болох гэрээ үйлчилж байв.

Ил тод нээлттэй улс төрийн бодлого байхаас гадна далд нууцлагдсан "танхимын" бодлого идэвхтэй явагдаж байсан. Улс орон бүр өөрсдөө хууль бус барааны жагсаалтыг тодорхойлох болсон нь далайн дээрэм тонуулыг идэвхжүүлсэн байна. Цэргийн эд зүйлийг дамлан наймаалах талаар хоёр талын гэрээ хийж байв. Тухайлбал, 1713 оны Утрехтийн гэрээг дурдаж болно.

1780 онд Орос орон цэрэг дайны асуудлаар Эвсэлд үл нэгдэх Тунхаг бичиг санаачилсан. Мөн далай тэнгисийн сав газар дайн хийх зарчим боловсруулсан байна. Тодруулбал, дайнд оролцоогүй улсын усан онгоц чөлөөтэй зорчих (дайтаж буй улсын эрэг орчимд ч гэсэн), дайнд оролцоогүй улсын усан онгоц түүний өмчийг тонохгүй байх (дайтагч талуудын ачаа байсан тохиолдолд ч гэсэн), хууль бус ашиг олох гэсэн барааны жагсаалт гаргах зэрэг заалт орсон байна.

1789-1793 онд Францад өрнөсөн хувьсгал нь олон улсын эрх зүйн хөгжилд тодорхой нөлөө үзүүлсэн. Хувьсгалын явцад дэвшүүлсэн ард түмний бүрэн эрх ба газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрөх, улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, гадаадын иргэдийн эрх зүйн байдлын асуудлыг эерэг шийдэх зэрэг үзэл санаа 1789 онд батлагдсан Хүний ба иргэний эрхийн Тунхагт, мөн 1792, 1793 оны Францын Үндсэн хуульд тусгалаа олсон байна. Гадаадын иргэд Францын иргэний нэгэн адил эрх эдлэх болсон. Мөн уг хувьсгалын үр дүнд бүх нийтийн энх тайван ба шударга ёс, булаан эзлэх дайны эсрэг, засаглалыг сонгох, үндсэн хууль болон улс орнуудын тэгш эрхийн тухай үзэл санааг түгэн дэлгэрсэн билээ.

Иргэн гэсэн ойлголтыг эргэн харж, хувь хүн зөвхөн иргэний үүрэгтэйгээс гадна бас эрх эдлэх ёстой гэдгийг тунхагласан. Мөн дайны үйл ажиллагаанд оролцогч ба энгийн ард иргэд гэсэн ойлголтыг салган ойлгох хэрэгтэй гэсэн асуудлыг дэвшүүлсэн. 1789 оны иргэн болон хүний эрхийн Тунхаг нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад их хувь нэмэр оруулсан гэж судлаачид дүгнэсэн байдаг. Тухайн үед (1648-1815) олон улсын харилцааг судлах чиг хандлага төлөвшиж олон улсын харилцаанд чухал нөлөө үзүүлэх болсон. Голландын хуульч, төрийн зүтгэлтэн Гуго де Грүүтийн дэвшүүлсэн үзэл санаанд тулгуурлан олон улсын эрх зүйн жам ёсны эрхийн ба позитив эрхийн гэсэн хоёр чиг хандлага үүссэн байна.

Х.Вольф, С.Пуффендорф нар "жам ёсны эрхийн" чиглэлийг төлөөлж байсан. К.Бинкерсхук, Р.Зеч, Ж.Ж.Мозер нар позитив эрх зүйчид байв. Германы хуульч, философич С.Пуффендорф олон улсын эрх зүйг жам ёсны эрхтэй адилтган үзэж, зан заншил дээр тулгуурласан эрх зүйн үйлдлийг үгүйсгэж байв. Тэрээр гэрээг олон улс эрх зүйн үндэс болж чадахгүй гэж үзсэн. Харин К.Бинкерсхук, Р.Зеч нар "жам ёсны эрхийг" бүрэн үгүйсгэсэн

байдаг. Жам ёсны болон позитив эрхийн аль алиныг нь хүлээн зөвшөөрч, нэгтгэн авч үзэн олон улсын эрх зүйн мөн чанарт тайлбар өгөх байр суурь байдаг. Швейцарийн эрдэмтэн Э.Ваттель олон улсын эрх зүй дээрх хоёр хэм хэмжээнээс бүтдэг гэж үзсэн. Жам ёсны эрхийг бүх ард түмэн, хүмүүс эдлэх учиртай. Позитив эрх нь төрийн үйл ажиллагааны бүтээгдэхүүн гэж Ваттель дүгнэсэн. Мөн улс орнууд тэгш эрхтэй гэсэн номлол дэвшүүлсэн. Жижиг улс, хүчирхэг улсын нэгэн адил бүрэн эрх эдлэх ёстой гэж үзсэн. Оросын хуульч, дипломатч Ф.Ф.Мартенс жам ёсны болон позитив эрхийг ялгаж байсан ч, позитив энгийн ба тохиролцооны гэж хоёр хуваагаад түүнд ач холбогдол өгч байв. Жам ёсны олон улсын эрх зүй нь дэлхийн ард түмнийг нэгтгэж байдаг. Позитив үйл ажиллагаа нь зөвхөн Европт үйлчилдэг гэжээ. Ф.Ф.Мартенс, Э.Ваттелийн бүтээлүүд XIX зууны олон улсын эрх зүйн шижлэх ухааны хөгжилд үлэмж нөлөө үзүүлсэн. ХҮИ зууны сүүлчээр олон улсын гэрээний эмхэтгэлүүд гарч эхэлжээ. "Code of the International Diplomatic Law" нэртэй анхны эмхтгэлийг 1693 онд Германы хуульч, дипломатч Г.В.Лейбниц гаргасан байна.

1791-1801 онуудад Ф.Ф.Мартенс "Собрание договоров о союзе" гэсэн найман боть эмхтгэл хэвлүүлжээ. Уг эмхтгэлд олон нэмэлт хийгдэж XX зууны эх хүртэл хэвлэгдэн гарч байв. Тухайн үед Орос оронд олон улсын эрх зүйн зарим асуудлыг хөндсөн ном зохиолууд бүтээгдсэн.

1795 онд Франц эзлэн түрэмгийлэх дайн өдөөн Вестфалийн гэрээгээр тогтоосон тэнцвэртэй байдлыг үгүй хийв. Дайн арван таван жил үргэлжилж, Францын их хувьсгалын үед дэвшүүлсэн олон улсын эрх зүйн дэвшилтэй үзэл санаанаас татгалзсан байна.

1804 онд Франц улс булаан эзлэх түрэмгий дайныг эрчимтэй явуулж эхэлсэн нь тухайн үеийн Европын улсуудын хооронд холбоотны гэрээ хэлэлцээр хийгдэж, хамтын хүчээр түрэмгийлэгчийн эсрэг зогсох улс орнуудын хамтын ажиллагаа өрнөхөд хүргэсэн. Тухайлбал, Орос Их Британи улстай Петербургийн гэрээ, Австри улстай Холбоотны тухай нууц Тунхаглал, Швед улстай холбоотны гэрээ тус тус байгуулсан байна. Гэвч 1805 оны 2 дугаар сард Францын эсрэг улсуудын холбооны цэрэг арми Аустерлийцийн дайнд ялагдал хүлээж салан бутарсан. Үүний дараа 1806 онд Наполеон Их Британи улсын эсрэг эдийн засгийн дайн дэгдээж "Британийн арлуудыг бүслэх" тухай баримт бичиг гаргаж байсан. Уг хуулийн дагуу Их Британи улстай хийх бүх харилцааг хориглож байсан ба Францын мэдэлд байсан газар нутаг дээр орших Их Британи улсын албат иргэдийг цэргийн олзлогдогсад болгож, өмч хөрөнгийг нь хураан авсан байна. Их Британи улсын хөлөг онгоцуудыг Францын далайн боомт руу оруулдаггүй байв. Уг хуулийг тухайн үед Европын олон улс даган мөрдөж байв.

1812 онд Франц улс Прустэй "Парисын холбоотны гэрээ" байгуулснаар Орос улсын эсрэг дайныг эхлүүлсэн. Орос Их Британи улстай энхийн гэрээ байгуулж Францын эсрэг дайтсанаар түүний ноёрхол Европт дуусгавар болов.

1815 оноос Дэлхийн I дайны төгсгөл хүртэл үеийн олон улсын эрх зүй

Эвслийн хүч Францыг ялснаар Европын улс төрийн газрын зураг өөрчлөгдсөн билээ. Энэ үед дайнд ялсан улсын хооронд тэнцвэртэй байдал, улс гүрнийг хүлээн зөвшөөрөх зарчим дээр үндэслэсэн олон улсын шинэ дэг журам бий болсон.

Уг хэм хэм хэмжээ бий болсноор улс гүрний газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалж, дотоод хэв журмаа хувьсгалаар эвдүүлэхгүй хамгаалах баталгаа бий болжээ. XIX зуунд Европын орнууд оролцон чуулсан хурал олон улсын харилцааны асуудлуудыг шийдвэрлэх болсон байна.

Наполеон ялагдсантай холбогдуулан 1814-1815 онд хуралдсан Венийн олон улсын хурал дээрх үйл явцын эхлэлийг тавьсан байна. Уг чуулганд Туркээс бусад Европын бүх улс оролцжээ. Венийн олон улсын хурал дээр баталсан баримт бичиг олон улсын эрх зүйн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Тодруулбал, Европын зарим гол мөрнөөр усан онгоц чөлөөтэй зорчих, Швейцарь улсын байнга төвийг сахисан статус болон янз бүрийн улс орны дипломат албаны дэв зэргийг нэг хэв маягт оруулсныг хүлээн зөвшөөрсөн баримт бичиг болсон. Мөн "Боолын худалдааг зогсоох тухай" Тунхаглал уг хурлаас гарсан нь хүний эрхийг хамгаалах салбарт нэн ач холбогдолтой зүйл болжээ.

Венийн олон улсын хурал дээр Орос, Прусс, Австри зэрэг улсаас бүрдсэн "Ариун холбоо" байгуулагдсан. Уг холбоонд хожим Англи, Франц улс нэгдэн орсон юм. "Ариун холбоо" нь ямар ч тохиолдолд болон хэдийд ч, хаана ч байсан Европт газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах баталгаа, тогтвортой хөгжлийг хамгаалах үүрэг хүлээсэн байна. 1821 онд Австри улс Неаполь, Сардини руу халдсан. Мөн 1823 онд Францын зэвсэгт хүчин хаант засаглалыг хамгаалах зорилгоор Испани руу дайтсан байна. 1848 онд Унгарт өрнөсөн хувьсгалт хөдөлгөөнтэй уялдан, дээрх зарчмын эсрэг агуулгатай, "дотоод хэрэгт үл оролцох" үзэл санаа дэвшүүлэгдсэн ажээ.

Уг холбооны хүрээнд олон улсын хурлыг үе үе зохион байгуулж байсан. Тухайлбал, 1818 оны Аахены, 1820 онд Троппаусын, 1821 онд Лайбахийн, 1822 онд Вероны чуулган тус тус зохион байгуулагдаж байжээ. Тэр дотроос 1815 оны Венийн олон улсын хурал удаан хугацаанд Европ болон дэлхийд хүчний шинэ тэнцвэрийг тогтоож өгсөн.

"Ариун холбоо" нь олон улсын эрх зүйн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан болно. Жишээлбэл, Венийн хурлын Төгсгөлийн Акт олон улсын болон хил орчмын гол мөрөн болох Рейн, Маасу, Мозелю ба Шельдийн усан замын тээврийн хураамжийн тухай дүрэм журмыг тогтоож өгсөн байдаг. Мөн зарим зүйл ангид нь боолын худалдааг хориглосон ба дипломат төлөөлөгчдийн зэрэг дэвийг тогтоох зорилготой хэм хэмжээг агуулж байв.

Аахены хуралд оролцогч улсуудын тунхагласан баримт бичигт олон улсын эрх зүй, энх тайван байдал, итгэл үнэмшил ба ёс суртахууныг дэмжихэд улс орны хамтын ажиллагааг өрнүүлэхийг уриалсан байна. Мөн тухайн үед өргөнөөр ашиглаж байсан дипломат төлөөлөгчдийн дэв зэргийг тодорхой болгосон. Уг дэв зэргийг "резидент элчин сайд" гэдэг байв. Орчин үед ийм дипломат дэв зэрэг байхгүй болно.

1822 онд Вероны их хурлаар Латин Америк дахь Испанийн колони улсууд руу Европын гүрнүүдийн "интервенци" явуулах боломжийн талаар хэлэлцэж байв.

Мөн энэ үед "Англизаксоны бүлэг" гарч ирсэн нь АНУ болон Их Британий холбоо юм. 1823 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Монро Конгресст хандсанаар "Монрогийн номлол" бий болсон юм.

Мөн үед хүний эрхийн талаар дэвшүүлсэн Францын хувьсгалын үзэл санаа хүний эрхийг хамгаалах олон улсын эрх зүйн зарчим, олон улсын эрх зүйн нэг салбар бий болоход

хүчтэй нөлөө үзүүлсэн. Гадаад улсын эрхшээлд байсан зарим нэг орон чөлөөлөгдөж, зарим нэг нь (Грек, Бельги, Итали, Болгар, Серби, Черногор, Румын) тусгаар тогтносон, бие даасан улс орон болох үндэс тавигджээ.

Гадаадын иргэдийн эрх зүйн байдалд эерэг нааштай өөрчлөлт гарч, зарим нэг оронд тухайн улсын иргэдийн нэгэн адил эрх эдлэх боллоо. Улс төрийн орогнох эрх ба цагаачлалын дэд салбар үүсэн бий болов.

Африкийг колоничлох явцад газар нутгийн маргаан үүсч, үүнтэй уялдан Берлинд 1884 онд олон улсын хурал зарлан хуралдуулсан байна. "Эзэнгүй газрыг" нээх эрх эдлэх нь тухайн газар нутгийг эзлэн түрэмгийлэх эрх зүйн үндэс болохгүй гэж уг хурал дээр шийдвэрлэсэн хэдий ч улс гүрэн газар нутгийг эзлэн авч засаглалаа тогтоох ба үр ашигтай бодлого явуулах ёстой гэжээ. Эзлэн авах үйл ажиллагаагаа нот бичгээр бусад улс оронд зарлах хэрэгтэй хэмээн их хурал үзсэн байна. Мөн уг хурал дээр Конго мөрнөөр усан хөлөг онгоц чөлөөтэй зорчих эрхтэйг тунхагласан байна.

Газар нутгийг өөрчлөх, мөн олж авах, мөнгө хөрөнгө оролцуулан худалдаж авахад ард түмний хэлэлцүүлгийг ашиглаж болно гэж тэр үеийн олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрсөн байна.

1860 онд Их Британи Грект Иони арлыг өгсөн. 1867 онд Оросууд Америкт Аляскийг зарсан байна. Улс газар нутгийг олж авах нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амыг бүхэлдээ эрхшээлдээ оруулна гэсэн үг биш юм. Тиймээс газар нутгаа өгсөн ард түмэн харъяаллаа сонгох эрх эдэлдэг байв. Хүн амаас санал асуулга авдаг арга ажиллагаа хийгдэх болсон. 1858 Румынд, 1860 онд Нинце, Савой зэрэг газар санал асуулга явагдсан. Мөн далайн орон зайг ашиглах, зохицуулах тухай олон асуудал үүсч, шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Загас болон далайн амьтдыг агнах талаар хоёр болон олон талын гэрээ хийгдэх болсон. Далайн булан болон тэр хавийн бүсийн талаар тодорхой нэр томъёо болон ойлголтууд бий болсон.

Шинжлэх ухаан-техникийн дэвшил нь олон улсын байгууллага бий болох нөхцлийг хангасан байна. 1864 онд Газар нутгийг хэмжих олон улсын холбоо, 1865 онд Олон улсын цахилгаан холбооны байгууллага, 1875 онд Жин хэмжүүрийн олон улсын хороо, 1886 онд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах олон улсын холбоо, 1890 онд Боолчлолын эсрэг олон улсын холбоо, 1890 онд Гаалийн тарифийг хэвлэн нийтлэх зорилготой олон улсын холбоо, мөн онд Төмөр замаар тээвэрлэх барааны талаар мэдээлэл хийх олон улсын холбоо байгуулагдсан.

Олон улсын харилцааг зохицуулахад их ач холбогдолтой гэрээний хэлбэрүүд бий болсон. Энх тайван болон газар нутгийн өөрчлөлтийн талаар хийгдсэн гэрээнээс гадна, худалдааны, далайд зорчих, консулын асуудлаар шүүхийн үйл ажиллагаанд тусалцаа үзүүлэх, гэмт хэрэгтнийг шилжүүлэх, загас агнуур, харилцаа холбоо, тээврийн асуудлаар болон далайн дээрэм, эмэгтэйчүүдийг худалдаалах болон садар самууныг хэвлэлээр сурталчлах зэрэг гэмт хэргийн эсрэг хийх тэмцлийн тухай олон талт гэрээнүүд байгуулагджээ.

Тухайн үеэс эхлэн олон улсын маргааныг олон улсын шүүхээр таслах болсон. Тухайлбал, 1870 онд "Алабама" цэргийн хөлөг онгоцны асуудлаар үүссэн маргаан, 1893 онд далайн

агнуур хийж байсан Америкийн хөлөг онгоцыг саатуулсантай холбоотойгоор Орос, АНУ хооронд үүссэн зарга, 1897 онд Британий Гвианы талаар Венесуэль, Их Британийн хооронд гарсан маргааныг шүүхийн шийдвэрээр зохицуулсан.

Дайны хууль дүрэм, заншилд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан. Дайны ажиллагаа явуулах арга хэрэгсэл, дүрэм тогтоохын тулд олон улсын хурлыг зарлан хуралдуулдаг болсон байна. Жишээлбэл, 1856 онд Парист "Тэнгисийн дайн хийх эрхийн тухай" Тунхаг гарсан нь 1780 онд баталсан "Дайны ажиллагаанд үл оролцох" тунхагийн үндсэн агуулгыг багтаасан байна. Уг тунхагт капер буюу дээрэм тонуул хийхийг хориглосон. 1868 онд Санкт-Петербургт болсон олон улсын хурлаар тэсрэх галт сум ашиглахыг хорьсон. 1899, 1907 онд Оросын санаачлагаар Гаагийн энх тайвны хурлыг зарлан хуралдуулсан. Уг хурал дээр дайны хууль, заншлын талаар баримт бичиг баталж, байнгын ажиллагаатай хөндлөнгийн шүүх байгуулсан ажээ.

1909 онд "Далайн дайны дүрмийн тухай" Лондонгийн Тунхаглал батлагдсан. Уг тунхаглалд цэргийн бүслэлт, дамын наймаа болон усан замын дайны зан заншлын хэм хэмжээг төрөлжүүлэн эмхтгэсэн. Дэлхийн I, II дайны үед уг тунхаглалын хэм хэмжээг дагаж мөрдөж байсан.

Вестфалийн энх тайвны гэрээ нь сонгодог олон улсын эрх зүй төлөвшихөд чухал нөлөө үзүүлсэн. Сонгодог олон улсын эрх зүйн субъект нь зөвхөн "соёл иргэншилт улсууд" гэж Европд үзэж байв. "Соёл иргэншилт улсууд" гэсэн нэр томъёог өнөөдөр ч хэрэглэдэг ба НҮБ-ын дүрэмд тусгасан байдаг. Уг гэрээнд Европын орнуудын эрх давуу тусгагдсан байв. XVII-XIX зуунд Европын улсууд Турк, Хятад, Япон зэрэг улстай гэрээ хийж байсан ч эдгээр улсыг сонгодог олон улсын эрх зүйн субъект гэж үздэггүй байжээ.

XIX зуунд олон улсын эрх зүйн шинжлэх ухаан үүсэн бүрэлдэж, жам ёсны болон позитив эрх гэсэн хоёр чиглэлээр хөгжсөн. Олон улсын эрх зүйн хөгжлийн явцад эерэг чиглэлд илүү ач холбогдол өгдөг болсон байна. Олон оронд олон улсын эрх зүйг хөгжүүлэх чиг хандлага үүссэн. Тухайлбал, Их Британид Ф.Филлимор, Г.Гвисса, У.Холл, Францад Ж.Рейневал, П.Прадье-Фодере, АНУ-д Г.Ултон, Ж.Кент, Т.Улс, Гепмемд И.Клюбер, А.Гефтер, Ф.Гольцендорф, Ф.Лист, Италид П.Флор, Швейцарт И.Блюнчли. Мөн энэ үед олон улсын эрх зүйн тусгай асуудал боловсрогдож эхэлсэн. Жишээ нь Италийн эрдэмтэн П.Манчини үндэстний асуудалд анхаарч, өөрийн бүтээлд үндэстэн бол хүмүүсийн жам ёсны нэгдэл гэж дүгнэсэн байдаг. Газар нутаг, үндэстэн ястны үүсэл гарал, зан суртахуун, хэл нэгтэйгээс нэгдмэл соёл, нийгмийн ухамсартай байдаг гэжээ. Өнөөдөр ч гэсэн үндэстэн гэсэн ойлголт нь "ард түмэн", "үндэстний цөөнх" зэрэг ойлголтын мөн чанарыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Орос оронд олон улсын эрх зүйн талаар сурах бичиг, гарын авлага гарч тодорхой тусгай сэдвийг гүнзгийрүүлэн судалсан байна. XIX зууны хоёрдугаар хагаст олон улсын эрх зүйн шинжлэх ухаан Орос оронд эрчимтэй хөгжсөн байдаг.

1919 оноос Дэлхийн II дайн хүртэл үеийн олон улсын эрх зүй

XIX зууны хоёрдугаар хагаст Герман улс Францыг ганцаардуулан тусгаарлах бодлого баримталж өөртөө холбоотон болох улсыг идэвхийлэн хайж байв. 1879 онд Австри-Унгарын цэргийн холбоо, 1882 онд Герман, Австри, Унгар ба Итали улсуудын хооронд

холбоотны гэрээ байгуулагдсан. Эндээс гурван талт холбоо байгуулах практик тогтсон байна. Талууд уг холбоонд оролцогч улсын эсрэг ямар нэгэн холбоо болон хэлэлцээнд оролцохгүй байх, улс төр болон эдийн засгийн асуудлаар зөвлөлдөх, өөр хоорондоо туслах тухай үүрэг хүлээсэн. Мөн гэрээнд оролцогч нэг улсын эсрэг хэд хэдэн улс довтлох тохиолдолд гэрээнд оролцогч хоёр улс дайнд оролцох тухай хэм хэмжээг тусгасан байна. Энэ холбооны эсрэг хариу болгож Франц, Орос болон Их Британи улс өөрсдийн "Entente cordiale" буюу Антантын холбоог байгуулсан. Уг холбоог Франц-Оросын 1893 оны гэрээ болон 1907 оны Орос-Их Британий хооронд хийсэн гэрээний үндсэн дээр баталсан байна.

1917 онд Орос оронд хувьсгал гарч, Зөвлөлт Орос улс байгуулагдсанаар олон улсын эрх зүйн уур амьсгалд тодорхой өөрчлөлт гарчээ. Тухайлбал, түрэмгий, колоничлох дайныг хорих, улс орныг албадан хавсаргах, дайны төлбөрийг болиулах, ард түмний тусгаар тогтнох эрхийг хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлыг хөндсөн байна. Уг хурлаар "Декрет о мире" ("Энх тайвны тухай Тунхаг") батлагдсан. Үүнд дайтаж буй бүх улс орнууд болон засгийн газруудад шударга болон ардчилсан замаар гэрээ хэлэлцээр хийхийг уриалсан. Мөн өмнө нь хийж байсан тэгш бус гэрээгээ цуцалсан байна. Дээрэм тонуул хийх зорилгоор үйлдэгдсэн дайныг "хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг" гэж үзсэн нь олон улсын эрх зүйн үндсэн зарчим үүсэхэд зохих хувь нэмрээ оруулсан.

1914-1919 онуудад дэгдсэн Дэлхийн I дайн хийгээд уг дайны төгсгөлд байгуулсан Версалийн энх тайвны гэрээ дэлхийн улс төрийн газрын зургийг өөрчлөөд зогсоогүй, олон улсын эрх зүйн хөгжилд чухал нөлөө үзүүлжээ.

Дэлхийн I дайны гай гамшиг дайныг хазаарлаж, дэлхий дахинд энх тайван тогтоох зайлшгүй шаардлагатай болохыг олон улсын хамтын нийгэмлэгт тод томруун ойлгуулсан билээ. Тиймээс ч 1919 онд Үндэстнүүдийн Холбоо байгуулагдаж, ахин дэлхийн дайн гаргуулахгүй байх, энх тайвныг сахин хамгаалах үүрэг хүлээсэн. Уг байгууллага байгуулагдсаны анхны жилд 44 орон гишүүнээр элсэж, 1932 он гэхэд 55 гишүүн оронтой болсон байна. Үндэстнүүдийн Холбооны гол байгууллагууд нь Ассамблей ба Зөвлөл байв. Зөвлөл нь Их Британи, Франц, Итали, Япон гэсэн байнгын 4 гишүүн орноос бүрдэж байв. Түүнээс гадна жил болгон солигддог байнгын бус 4 гишүүн улстай байв. Ерөнхий нарийн бичгийн даргатай, байнгын үйл ажиллагаатай нарийн бичгийн даргын газар нь Женев хотноо байрладаг байсан.

Үндэстнүүдийн Холбооны Дүрэмд олон улсын эрх зүйн хөгжилд нөлөөлсөн хэд хэдэн хэм хэмжээ тусгагдсан. Тухайлбал, гишүүн улсуудын хооронд гарсан маргааныг шийдвэрлэж байх дүрмийг баталжээ. Хэрэв гишүүн улс Үндэстнүүдийн Холбооны Дүрмийг зөрчин дайн хийх тохиолдолд бүх гишүүн улсын эсрэг дайн хийсэнд тооцно гэж заасан. Гэвч маргааныг шийдвэрлэх зорилгоор дайн хийхийг хориглосон боловч дайн тасрахгүй байв. Тухайлбал, 1931 онд Япон улс Хятад руу халдаж, Манжуурыг эзлэн авсан. Үүний улмаас Япон улсыг Үндэстнүүдийн Холбооноос хөөсөн бөгөөд 1934 онд Герман, Итали хоёр өөрсдөө уг холбооноос гарсан. 1935-1936 онд Итали улс Этиопийн эсрэг дайн хийж, Герман улс 1936 онд Версаль болон Локарны гэрээг зөрчин Рейн орчмын газар нутгийг эзлэн авсан байна.

Үндэстнүүдийн Холбоо өөрийн гишүүн улсуудын өдөөсөн дайныг зогсоож чадаагүй ч уг байгууллага нь үр нөлөөтөй олон улсын байгууллага бий болгох замыг тавьсан нь Нэгдсэн Үндэстний Байгууллага байлаа.

Версалийн энх тайвны гэрээний нэг хэсэгт хөдөлмөрийн асуудлын олон улсын зохицуулалтын хэм хэмжээг тусгаж өгснөөр 1919 онд олон улсын иргэдийн нийгмийн эрхийн асуудлыг тусгайлан хариуцсан Олон улсын хөдөлмөрийн байгууллага бий болсон.

1919-1939 онуудад түрэмгий харгис дайныг хориглох шаардлагатай гэдгийг улс орнууд ухамсарлан ойлгож байсан үе юм. Үүнтэй уялдан дайныг улс орны улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх хэрэгсэл мэтээр үзэхгүй байх, дайнаас татгалзах тухай Парисын гэрээг 1928 онд баталсан ч түрэмгий харгис дайнд нийтээрээ хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт өгөх асуудал тавигдаж байлаа. 1933 онд Зөвлөлт Орос улсын санаачлагаар түрэмгийллийг тодорхойлох улс хоорондын гэрээ байгуулж, түүнд ЗХУ, Эстони, Латви, Польш, Румын, Турк, Перс, Афганистан улс нэгдсэн байна.

Хүний эрхийг хангах салбарт тодорхой алхмууд хийгдсэн. 1926 онд "Боолчлолыг хориглох тухай" олон улсын гэрээ байгуулагдаж, 1928 онд улс төрийн орогнол хайгчдын эрх зүйн байдлын талаар олон улсын гэрээ хийгдсэн.

Үндэстнүүдийн Холбоо 1930 онд чуулганаа хуралдуулах санаачлага гаргасан ч хэрэгжээгүй болно.

Олон улсын энх тайван ба аюулгүй байдлын асуудлыг онцлон судлах болсон. Румыны эрдэмтэн В.Пелла түрэмгий дайн өдүүлсэн хариуцлагын тухай судалгаа хийсэн нь олон улсын аюулгүй байдлын хуулийн салбар үүсэх эхийг тавьсан.

Мөн энэ үед Өрнөдөд Австрийн хуульч, философич Г. Кельзений үндэслэсэн олон улсын эрх зүйн норматив дэг сургууль үүссэн. Олон улсын болон үндэсний эрх зүй нь нэг эрх зүйн систем ба олон улсын эрх зүй нь үндэсний эрх зүйгээс дээгүүр тавигддаг гэж норматив онолд үздэг байна. Уг онолд хэн ч, хэзээ ч, ямар ч тохиолдолд зөрчиж болохгүй хэсэг хэм хэмжээг тодотгож өгсөн юм. Ийм хэм хэмжээний тоонд *Pacta sunt servanda* багтдаг ба түүнд олон улсын болон үндэсний эрх зүй захирагдаж байдаг гэсэн онол бий болсон.

П.Фошиль, Ч.Хайд, У.Холл зэрэг олон улсын эрх зүйч, эрдэмтэд олон улсын эрх зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан.

Дэлхийн II дайн ба олон улсын эрх зүй

XX зууны 20-иод оноос эхлэн Германы дорно зүгт хийх түрэмгийлэл эхэлсэн билээ. Тухайлбал, 1922 онд Бельги, Их Британи, Герман, Итали, Франц улсуудын хооронд байгуулагдсан Локарны гэрээгээр Рейн мөрөн орчмын баруун хэсэгт газар нутгийн статус-квог хамтаар болон дангаар хадгалах баталгааг бий болгосон. Үүнийг "Рейны баталгааны гэрээ" гэж нэрлэсэн байдаг. Уг гэрээ ёсоор бие биенийхээ эсрэг дайн хийхгүй байх ба маргааныг арбитрийн хэлэлцээрийн дагуу шийдвэрлэх журмыг тогтоосон. Дорно зүгийн хилийн талаар гэрээнд оролцогч улсууд ямар нэгэн баталгаа гаргаагүй нь Германд ашигтай гэрээ болсон юм.

Энэ үед Герман, Итали болон Японд фашизмын үзэл суртал дэлгэрч байсан бөгөөд 1936 онд Герман улс Локарны гэрээг цуцлан Рейн орчмын бүсэд цэргээ оруулж ирснээр

Дэлхийн II дайны эхлэх суурь тавигдсан. Энэ үед их гүрнүүдийн дунд Чехословакийг хуваах Мюнхены гэрээ хийгдсэн. 1939 оны 3 сард Герман улс Чехословакийг, 9 сард Польшид халдсанаар Дэлхийн II дайн дэгдэж их гүрнүүд хагаралдан өөр хоорондоо дайтаж, "холбоотны гэрээ" хийж байв. Тухайлбал, 1941 онд АНУ, Их Британи улсууд ЗХУ-ыг дэмжихээ илэрхийлж, харилцан туслах болон хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. 1943 оны Москва, Тегераны хэлэлцээр, 1945 оны Ялтын болон Потсдамын хэлэлцээрийн үр дүнд олон улсын эрх зүйн хөгжлийн шинэ үе шат болон олон улсын хамтын ажиллагаа эхэлсэн.

Ингэснээр сонгодог олон улсын эрх зүй түүх болон үлдэж, орчин үеийн олон улсын эрх зүйн үе шат эхэлсэн. Орчин үеийн олон улсын эрх зүйн тодорхой системтэй болж, олон улсын эрх зүйн шинэ салбарын үндэс тавигдсан байна. Тухайлбал, олон улсын эдийн засгийн эрх зүй, олон улсын эрүүгийн эрх зүй гэх мэт. Олон улсын эрх зүй түгээмэл шинжтэй болсон ба Европ тивээс хальж, улс орон бүр олон улсын эрх зүйн дагуу үүрэг хүлээх болсон. Мөн энэ үеийн гол онцлог нь НҮБ-ыг үүсгэн байгуулсан явдалд оршино. НҮБ бий болсноор түрэмгий дайныг улс орнууд хийхийг хориглох явдлыг хуульчилсан. Үүний хамт, улс орнууд хуулийн дагуу хамтын ажиллагаа өрнүүлэх үүрэг хүлээх болсон. Олон улсын эрх зүйн системийн эргэлт нь эмх журмыг тогтоож олон улсын эрх зүйн шинэ зохицуулалтын арга хэрэгслийг шаардах болсон байна. Олон улсын эрх зүйн системд гарсан ийм өөрчлөлт нь эмх журмыг тогтоох боломж бүрдүүлэн, олон улсын эрх зүйн шинэ зохицуулалтын арга хэрэгслийг шаардах болсон.

Орчин үеийн олон улсын эрх зүй

1945 онд байгуулагдсан НҮБ нь орчин үеийн олон улсын эрх зүйн эхийг тавьсан төдийгүй түүний төлөвшил, хөгжилд дараах үйл явдлууд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Үүнд:

- Социалист системийн үүсэл (Польш, Ардчилсан Герман улс (Зүүн Герман), Чехословак, Унгар, Румын, Болгар, Югослав, Албан, Хятад, Вьетнам, Хойд Солонгос, Монгол);
- Колонийн системийн задрал (дэлхийн газрын зураг дээр шинээр тусгаар тогтносон улсууд бий болсон);
- Социалист системийн задрал (социалист орнууд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас хувийн өмчид тулгуурласан зах зээлийн эдийн засагт шилжив);
- Өрнөдийн улсуудын аж үйлдвэржилт;
- Хүн төрөлхтөнд заналхийлсэн глобал асуудлууд бий болсон гэх мэт.

Олон улсын хамтын нийгэмлэгийн гол зорилго нь энх тайван, олон улсын аюулгүй байдлыг сахин хамгаалах явдал бөгөөд НҮБ түүнийг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь болдог. Хэдийгээр өнөөг хүртэл дэлхий дахинд зэвсэгт мөргөлдөөн тасрахгүй байгаа ч энх тайван, тогтвортой нөхцлийг бий болгоход энэ байгууллага их зүйл хийснийг үгүйсгэх аргагүй.

Олон улсын эрх зүйн хөгжлийн үе шатыг тодорхой нарийн хил хязгаараар зааглах боломжгүй юм. Учир нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэх үйл явц байнга явагддаг

бөгөөд хуучирсан хэм хэмжээнүүд солигдож, үйлчилж буй нь шинэчлэгдэж байдаг. Тиймээс ч орчин үеийн олон улсын эрх зүй нь урьд өмнөхөөсөө эрс ялгардаг.

Сонгодог олон улсын эрх зүйгээс орчин үеийн олон улсын эрх зүй нь хэд хэдэн зүйлээр ялгаатай. Соёлжиж иргэншсэн улс орон л олон улсын эрх зүйн субъект байна гэж сонгодог олон улсын эрх зүй үзэж байсан бол орчин үеийн олон улсын эрх зүй нь дэлхийн улс орон бүрийг олон улсын эрх зүйн субъект гэж үздэг. Орчин үеийн олон улсын эрх зүйд олон улсын байгууллагыг олон улсын эрх зүйн субъект гэж үзсэн ч олон улсын эрх зүйн субъектийн эрхтэй улсаас ялгаатай, хоёрдогч шинжтэй гэж онцолсон байна. Түүнчлэн улс орнуудын эрх үүрэг тодорхой болсон ба императив хэм хэмжээ бий болсон. Олон улсын маргааныг зөвхөн тайван замаар, яриа хэлэлцээний аргаар шийдвэрлэхийг чухалчлах болсон. Эрт үед олон улсын эрх зүйн тогтолцоонд зан заншил голлох эх сурвалж болж байсан бол орчин үед олон улсын гэрээний үүрэг өссөн. Дипломат болон консулын эрх зүй, олон улсын гэрээний эрх зүй, олон улсын далайн эрх зүй зэрэг олон улсын эрх зүйн олон салбар системчлэгдэн хуульчлагдсан байна.

Олон улсын харилцааны тодорхой асуудлуудыг олон улсын эрх зүйгээр зохицуулах шаардлага бий болсоноор олон улсын эрх зүйн шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж эхлэв. Хүний эрхийн асуудал олон улсын хамтын ажиллагааны үндэс болсон. Зөвхөн гэрээ байгуулах замаар улс орнууд өөрийн иргэдийг зохих эрх, эрх чөлөөгөөр хангах үүрэг хүлээгээд зогсохгүй, хүний эрхийн салбарт хүлээх улсуудын үүргийг хянах механизмыг бий болгосон. Мөн зэвсэглэлийг хязгаарлах эхний алхам энэ үед хийгдсэн.

Өнөөдөр улсуудын ашиг сонирхлыг зохицуулах шинэ арга хэрэгслийг хайж байна. Өмнө нь улсууд дангаараа ашиг сонирхлоо хамгаалах бодлого баримталдаг байсан бол өнөөдөр хамтын хүчээр олон улсын эрх зүйг хэрэглэх хандлага бий болсон.

НОМ ЗҮЙ

1. Курс международного права. В семи томах. Том 1. Понятие, предмет и система международного права. Р.А.Мюллерсон, Г.И.Тункин. 1989.
2. Ф.Ф.Мартенс Современное международное право цивилизованных народов.Т.1. СПб., 1904. М.1996.
3. И.И.Лукашук.Международное право. Общая часть.М., 2005.
4. Гроций Г. О праве войны и мира. 1956.
5. Я.Броунли. Международное право. Книга первая. В двух книгах. Москва. 1977.
6. В.М.Шумилов. Международное право. Учебник. Велби. 2008.
7. Русско-Английский юридический словарь. У.Э.Батлер. Москва. 2001.
8. Международное право. Отв. Ред. В.И.Кузнецов, Б.Р.Тузмухамедов. Москва. 2007.
9. История государства и права зарубежных стран. Часть. 2. Учебник для ВУЗОВ. Москва. 2002.
10. Международное право. Учебник. Отв. Ред. Ю.М.Колосов, Э.С.Кривчикова. МГИМО. 2007.
11. Всемирная история. М. 2010.
12. Дүгэрсүрэн М. Хосбаяр О. Олон улсын эрх зүй. УБ. 1999.
13. Дэлхийн хамгийн анхны гэрээ: Египет ба Хиттите. Стратеги судлал. №1. Стратегийн судалгааны хүрээлэн. 2002.
14. Дэлхий дахины түүх. 1,2 боть, ред. Ж. Болдбаатар, З.Баасанжав. 2003.
15. ХҮІ-ХІХ зууны үеийн Баруун Европ. УБ. З.Баасанжав, Д.Наранцэцэг.2000 он.
- 16.Э.Тамир.Дорно дахины товч түүх.УБ.2002
17. Энтин. Европейское право. М. 2004.
18. Петер Кунцман, Франц-Петер Буркард, Франц Видман. Философия. М. 2002.